



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар A/434

Мандалговь

Эйч Ар Ви Констракшн ХХК-тай нэмэлт
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 34 дугаар зүйлийн 34.2, 34.1.4 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх “Сайнцагаан сумын 1-р цэцэрлэгийн барилга, 150 ор” ХХК-тай байгуулсан БСШУСЯ/201902151-ний дугаартай 1,461,289,368 (нэг тэрбум дөрвөн зуун жаран нэгэн сая хоёр зуун наян есөн мянга гурван зуун жаран найм) төгрөгийн гэрээний дүнг 79,962,095 (далан есөн сая есөн зуун жаран хоёр мянга ерэн тав) төгрөгөөр нэмэлт гэрээ байгуулсугай.

Хоёр. Нэмэлт батлагдсан зураг төсвийн дагуу “Сайнцагаан сумын 1-р цэцэрлэгийн барилга, 150 ор”-ыг чанартай хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Эйч Ар Ви Констракшн” ХХК-ны захирал (Д.Ундармаа)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай нэмэлт гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнсүрэн), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), Сайнцагаан сумын Засаг дарга (Р.Мөнхтогтох), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



488191230